



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/119/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> "ЦЭСБ АУДИТ" ХХК-ийн аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 9511 Цахим хаяг: <a href="mailto:tseb.audit@gmail.com">tseb.audit@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13
3.Аудитын тайлан.....	6
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Албан шаардлага, Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ц.УРАНБОДОЛ ТАНАА

2022.02.25 № СЭА-2022-119-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>76,136,599.52</u></b>	<b><u>97,268,794.52</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>76,136,599.52</b>	<b>97,268,794.52</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>18,772,332.91</b>	<b>18,829,432.91</b>
35110	Тусгай зориулалттай материал	18,772,332.91	18,772,332.91
35130	Эм боох материал	-	57,100.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>57,364,266.61</b>	<b>78,439,361.61</b>
35410	Бичиг хэргийн материал	2,901,750.00	5,617,250.00
35420	Аж ахуйн материал	36,795,966.61	51,279,061.61
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,752,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,666,550.00	19,791,050.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,406,525,787.58</u></b>	<b><u>2,489,009,946.85</u></b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,406,525,787.58</b>	<b>2,489,009,946.85</b>
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,353,035,787.58</b>	<b>2,435,269,946.85</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,201,598,417.90	2,201,598,417.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,430,124.00)	(104,848,966.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,500.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	157,127,852.94	173,447,059.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(110,220,327.25)	(43,682,631.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,164,111.73	96,839,935.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,919,100.83)	(20,729,645.81)
39209	Зам, гүүрийн байгууламж	33,238,231.46	31,515,231.46
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,889,893.47)	(3,818,388.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	91,429,346.81	91,429,346.81
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25,328,116.83)	(32,158,387.95)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	27,265,389.12	31,115,476.14

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>53,490,000.00</b>	<b>53,740,000.00</b>
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	53,490,000.00	53,490,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,482,662,387.10</b>	<b>2,586,278,741.37</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,482,662,387.10</b>	<b>2,586,278,741.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,482,662,387.10</b>	<b>2,586,278,741.37</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,041,714,376.20	1,041,714,376.20
51101	Өмч: - төрийн	1,041,714,376.20	1,041,714,376.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>437,764,162.21</b>	<b>541,380,516.48</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	437,764,162.21	437,764,162.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	103,616,354.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,003,183,848.69	1,003,183,848.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,482,662,387.10</b>	<b>2,586,278,741.37</b>

## 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,317,698,643.88</b>	<b>1,068,154,451.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,451,603,846.88</b>	<b>158,478,808.24</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,451,603,846.88</b>	<b>158,478,808.24</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,451,603,846.88	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,451,603,846.88	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		143,228,962.24
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		15,249,846.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>866,094,797.00</b>	<b>909,675,643.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>772,412,100.00</b>	<b>774,331,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	772,412,100.00	774,331,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>458,320.00</b>	<b>8,855,043.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	5,027,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	458,320.00	328,043.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>93,224,377.00</b>	<b>126,488,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,224,377.00	126,488,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>916,056,853.41</b>	<b>963,218,807.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>916,056,853.41</b>	<b>963,218,807.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>835,922,271.68</b>	<b>906,123,134.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>559,946,718.46</b>	<b>564,339,098.70</b>
210101	Үндсэн цалин	397,431,328.85	394,416,233.83
210102	Нэмэгдэл	117,033,526.38	140,302,322.94
210104	Урамшуулал	45,481,863.23	29,620,541.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>70,088,059.81</b>	<b>73,301,009.10</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,263,966.30	51,381,373.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,678,113.52	5,651,586.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,502,170.36	4,521,288.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,058,528.37	1,059,361.83
210205	Эрүүл мэндийн даатгал	10,585,281.26	10,687,398.71
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,555,677.00</b>	<b>117,263,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,022,621.00	7,475,364.00
210302	Түлш, халаалт	83,462,856.00	105,325,636.00
210303	Цэвэр, бохир ус	4,070,200.00	4,462,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,638,827.30</b>	<b>7,538,451.00</b>
210401	Бичиг хэрэг	373,700.00	930,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	800,000.00

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	365,000.00	1,653,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,396,500.00	2,240,351.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	969,100.00	1,472,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	441,200.00
210408	Бараа материал акталсны зардал	16,334,527.30	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,542,680.00</b>	<b>41,071,120.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	358,500.00	240,000.00
210502	Хоол, хүнс	28,184,180.00	40,831,120.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,461,320.00</b>	<b>10,441,143.00</b>
210604	Урсгал засвар	2,461,320.00	10,441,143.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>262,700.00</b>	<b>258,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	262,700.00	258,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,817,800.00</b>	<b>4,017,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	991,800.00	2,577,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	1,440,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,608,489.11</b>	<b>87,892,613.03</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,064,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,128,000.00	3,620,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	55,416,289.11	84,272,213.03
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,134,581.73</b>	<b>57,095,672.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,524,340.00</b>	<b>24,796,980.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,724,340.00	24,296,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	500,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>67,610,241.73</b>	<b>32,298,692.20</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,610,241.73	32,298,692.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,401,641,790.47</b>	<b>104,935,644.21</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	1,319,289.94
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,319,289.94
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	1,319,289.94
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,401,641,790.47</b>	<b>103,616,354.27</b>

### 3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>866,094,797.00</b>	<b>909,675,643.00</b>
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>866,094,797.00</b>	<b>909,675,643.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>772,412,100.00</b>	<b>774,331,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	772,412,100.00	774,331,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>458,320.00</b>	<b>8,855,043.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,027,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	458,320.00	328,043.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>93,224,377.00</b>	<b>126,488,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,224,377.00	126,488,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>846,662,797.00</b>	<b>884,828,943.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>846,662,797.00</b>	<b>884,828,943.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>767,123,815.27</b>	<b>827,733,270.80</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>559,946,718.46</b>	<b>564,339,098.70</b>
210101	Үндсэн цалин	391,531,328.85	394,643,875.03
210102	Нэмэгдэл	122,933,526.38	136,309,500.00
210104	Урамшуулал	45,481,863.23	33,385,723.67
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>70,088,059.81</b>	<b>73,301,009.10</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,263,966.30	51,381,373.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,678,113.52	5,651,586.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,502,170.36	4,521,288.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,058,528.37	1,059,361.83
210205	Эрүүл мэндийн даатгал	10,585,281.26	10,687,398.71
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,555,677.00</b>	<b>117,263,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,022,621.00	7,475,364.00
210302	Түлш, халаалт	83,462,856.00	105,325,636.00
210303	Цэвэр, бохир ус	4,070,200.00	4,462,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,082,800.00</b>	<b>6,771,700.00</b>
210401	Бичиг хэрэг	388,700.00	930,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	365,000.00	1,653,700.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,191,000.00	1,267,600.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,918,100.00	2,119,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,151,540.00</b>	<b>43,252,720.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	358,500.00	297,100.00
210502	Хоол, хүнс	27,174,140.00	40,831,120.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,618,900.00	2,124,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,461,320.00</b>	<b>12,193,143.00</b>
210604	Урсгал засвар	2,461,320.00	12,193,143.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>262,700.00</b>	<b>258,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	262,700.00	258,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,817,800.00</b>	<b>6,717,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	991,800.00	5,277,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	1,440,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,757,200.00</b>	<b>3,636,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,294,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,463,000.00	3,636,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>79,538,981.73</b>	<b>57,095,672.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>11,928,740.00</b>	<b>24,796,980.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,128,740.00	24,296,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	500,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>67,610,241.73</b>	<b>32,298,692.20</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,610,241.73	32,298,692.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>19,432,000.00</b>	<b>24,846,700.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>19,432,000.00</b>	<b>24,846,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,432,000.00</b>	<b>24,846,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>19,432,000.00</b>	<b>24,846,700.00</b>
223001	Бусад хөрөнгө	19,432,000.00	24,846,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>- 19,432,000.00</b>	<b>24,846,700.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

#### 4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,041,714,376.20</b>	<b>1,003,183,848.69</b>	(963,877,628.26)	<b>1,081,020,596.63</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,041,714,376.20</b>	<b>1,003,183,848.69</b>	<b>(963,877,628.26)</b>	<b>1,081,020,596.63</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			1,401,641,790.47	1,401,641,790.47
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,041,714,376.20</b>	<b>1,003,183,848.69</b>	<b>437,764,162.21</b>	<b>2,482,662,387.10</b>
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,041,714,376.20</b>	<b>1,003,183,848.69</b>	<b>437,764,162.21</b>	<b>2,482,662,387.10</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,041,714,376.20</b>	<b>1,003,183,848.69</b>	<b>437,764,162.21</b>	<b>2,482,662,387.10</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			103,616,354.27	103,616,354.27
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,041,714,376.20</b>	<b>1,003,183,848.69</b>	<b>541,380,516.48</b>	<b>2,586,278,741.37</b>

**5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>901,466,300.00</b>	<b>868,521,907.80</b>	<b>32,944,392.20</b>	<b>96.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>901,466,300.00</b>	<b>847,175,207.80</b>	<b>54,291,092.20</b>	<b>94.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>870,211,400.00</b>	<b>822,378,227.80</b>	<b>47,833,172.20</b>	<b>94.5</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>569,314,200.00</b>	<b>564,339,098.70</b>	<b>4,975,101.30</b>	<b>99.1</b>
210101	Үндсэн цалин	398,740,900.00	394,643,875.03	4,097,024.97	99.0
210102	Нэмэгдэл	136,309,500.00	136,309,500.00	-	100.0
210104	Урамшуулал	34,263,800.00	33,385,723.67	878,076.33	97.4
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,595,500.00</b>	<b>73,301,009.10</b>	<b>1,294,490.90</b>	<b>98.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,822,900.00	51,381,373.31	441,526.69	99.1
210202	Тэтгэмжийн даатгал	5,693,200.00	5,651,586.32	41,613.68	99.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,554,500.00	4,521,288.93	33,211.07	99.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,138,700.00	1,059,361.83	79,338.17	93.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,386,200.00	10,687,398.71	698,801.29	93.9
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>117,909,000.00</b>	<b>117,263,300.00</b>	<b>645,700.00</b>	<b>99.5</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,092,700.00	7,475,364.00	617,336.00	92.4
210302	Түлш, халаалт	105,354,000.00	105,325,636.00	28,364.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,462,300.00	4,462,300.00	-	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,391,400.00</b>	<b>6,044,700.00</b>	<b>346,700.00</b>	<b>94.6</b>
210401	Бичиг хэрэг	656,900.00	656,900.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,653,700.00	1,653,700.00	-	100.0
210404	Ном, хэвлэл	346,700.00	-	346,700.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	814,600.00	814,600.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,119,500.00	2,119,500.00	-	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>62,823,900.00</b>	<b>43,252,720.00</b>	<b>19,571,180.00</b>	<b>68.8</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	297,100.00	297,100.00	-	100.0
210502	Хоол, хүнс	60,402,300.00	40,831,120.00	19,571,180.00	67.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,124,500.00	2,124,500.00	-	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,865,100.00</b>	<b>11,865,100.00</b>	<b>21,000,000.00</b>	<b>36.1</b>

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	-	12,000,000.00	0.0
210602	Тавилга	9,000,000.00	-	9,000,000.00	0.0
210604	Урсгал засвар	11,865,100.00	11,865,100.00	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>258,800.00</b>	<b>258,800.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	258,800.00	258,800.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,417,100.00</b>	<b>2,417,100.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	977,100.00	977,100.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,440,000.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,636,400.00</b>	<b>3,636,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,636,400.00	3,636,400.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,254,900.00</b>	<b>24,796,980.00</b>	<b>6,457,920.00</b>	<b>79.3</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,254,900.00</b>	<b>24,796,980.00</b>	<b>6,457,920.00</b>	<b>79.3</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,754,900.00	24,296,980.00	6,457,920.00	79.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>21,346,700.00</b>	<b>(21,346,700.00)</b>	
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>21,346,700.00</b>	<b>(21,346,700.00)</b>	
223001	Бусад хөрөнгө	-	21,346,700.00	(21,346,700.00)	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>901,466,300.00</b>	<b>900,820,600.00</b>	<b>645,700.00</b>	<b>99.9</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>774,331,700.00</b>	<b>774,331,700.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	774,331,700.00	774,331,700.00	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>127,134,600.00</b>	<b>126,488,900.00</b>	<b>645,700.00</b>	<b>99.5</b>
132001	Орон нутгийн төсвөөс	127,134,600.00	126,488,900.00	645,700.00	99.5

## 6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>8,855,043.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>5,355,043.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		5,355,043.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>727,000.00</b>
210401	Бичиг хэрэг	-	274,000.00
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210404	Ном, хэвлэл	-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		453,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	328,043.00
210601	Урсгал засвар	-	328,043.00
210602	Тавилга	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг, ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>3,500,000.00</b>
	Дотоод эх үүсвэр		3,500,000.00
<b>223001</b>	<b>Бусад хөрөнгө</b>		3,500,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>8,855,043.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>8,855,043.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,027,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		328,043.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Зүүнбүрэн сумын ЕБС гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ Аудит” ХХК-ийн захирал, аудитор Ч.Цэрэннадмид, ахлах аудитор Ш.Ганчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/59 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Зүүнбүрэн сумын ЕБС тайлант онд “Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллая” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажиллажээ. Үүнд:

1. Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах боломж, нөхцөлийг бүрдүүлж, сургууль завсардалгүй сургах

2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, цахим болон даалгаврын сан бүрдүүлэн ажиллах

3. Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүйгээ хөгжүүлж, хамтран ажиллах

4. "Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж" арга хэмжээний хүрээнд сургууль, цэцэрлэг бүрийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэн, эрүүл, аюулгүй, ээлтэй орчинг бүрдүүлэх,

5. Судалгаа, арга зүйн байгууллагуудтай хамтран ажиллаж, сургалтын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн, сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулж ажиллах.

Тус сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Суурь болон бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- БШУ-ны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн А/05, А/10, 1 тоот хамтарсан тушаал "Шалгуур үзүүлэлт шинэчлэх тухай" ур чадвар
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 32 дугаар зүйлийн 1 дүгээр зүйл-д НДШ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### **3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн сумын ЕБС нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийн нийт дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Бага" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 901,466.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 18,029.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14,423.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зүүнбүрэн сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103,616.3 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Хувь хүнээс авах авлага			
Бараа материал	76,136.6	97,268.8	21,132.2
Үндсэн хөрөнгө	2,406,525.8	2,489,009.9	82,484.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,482,662.4</b>	<b>2,586,278.7</b>	<b>103,616.3</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,482,662.4	2,586,278.7	103,616.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,482,662.4</b>	<b>2,586,278.7</b>	<b>103,616.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 97,268.8 мянган төгрөг болж 21,132.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 95,905.1 мянган төгрөгийн материал худалдан авсан, хандиваар 15,249.9 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, 90,022.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,665,125.9 мянган төгрөг болж өмнөх оноос 29,122.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 21,346.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан болон БШУЯ-наас 37,835.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, хандив тусламжаар 3,500.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүйгээр хүлээн авч, сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 58 дугаар тогтоолоор 33,560.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,586,278.7 мянган төгрөг болж 103,616.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,068,154.4 мянган төгрөг болж өмнөх оноос 1,249,544.1 мянган төгрөгөөр буюу 46.1 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 963,218.8 мянган төгрөг болж өмнөх оноос 47,162.0 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Зүүнбүрэн сумын ЕБС нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,016,751.3 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 115,285.0 төгрөгөөр бууруулж, 901,466.3 мянган төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр **901,466.3 мянган** төгрөгийн төсөв баталсныг тусгай зориулалтын шилжүүлгээс 774,331.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 127,134.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 774,331.7 мянга, орон нутгийн төсвөөс 126,488.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 900,820.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 868,521.9 мянган төгрөгийг зарцуулж, 32,298.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **868,521.9** мянган төгрөг буюу 96.3 хувьтай тайлагнагдсан нь цалин хөлс, НДШ-ийн зардал 6,269.6 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 19,571.2 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 6,457.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БШУЯ-ны төсөл хөтөлбөрөөс 4,300.0 мянган төгрөг, БСУГ-аас 1,055.0 мянган төгрөг, хандиваар 3,500.0 мянган төгрөгийн зэрэг нийт 8,855.0 мянган төгрөг төвлөрснийг хөрөнгө худалдан авахад 3,500.0 мянга, сургалтын үйл ажиллагаанд 4,300.0 мянга, урсгал засварт 328.0 мянга, бичиг хэрэг, ариутгалын зардалд 727.0 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт**

**3.7.1** БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын

хоёрдугаар хавсралт “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Зүүнбүрэн сумын ЕБС нь тайлант оны үйл ажиллагаанд 901,466.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 868,521.9 мянган төгрөг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.7 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 62,682.4 мянган төгрөгөөр шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 6,113.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 375.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,737.7 төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

#### **4.1 Төлбөрийн акт**

1.Тус сургуулийн захирал Ц.Уранбодолд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 2,4 дүгээр улиралд 58-59 хувиар тооцож, 375.4 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын үндсэн цалингийн **15 хүртэл хувьтай тэнцэх** хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Илүү олгосон улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

#### **4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

##### **1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:**

1.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

##### **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: БШУЯ-ны төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр худалдан авсан 2,395.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хангамжийн бараа, материал дансанд бүртгэсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.33-т заасантай нийцэхгүй бөгөөд “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 2022 оны эхний хагас жилд багтаан үндсэн хөрөнгийн ангилалд шилжүүлэн бүртгэх

##### **3. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд**

3.1 Илрүүлэлт: Тайлант онд бараа материал худалдан авсан 3,342.7 мянган төгрөгийн бараа, материалын төлбөрийн баримт цахим системд шивэгдээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1

дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зүүнбүрэн сумын ЕБС	4	6,113.1			1	375.4			3	5,737.7